



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС








2026 II

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр		4
I	 ЭРҮҮЛ МЭНД	5
II	 ТӨСӨВ	9
III	 НИЙГМИЙН ДААТГАЛ	13
IV	 НИЙГМИЙН ХАЛАМЖ	16
V	 ГЭМТ ХЭРЭГ	19
VI	 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	25
VII	 ХӨДӨӨ АЖ АХУЙ	29
ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ		30

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин
- ¹ товчилсон үгийн тайлбар

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.


IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

ХҮСНЭГТ 1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 II	2023 II	2024 II	2025 II	2026 II	
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	4 146 ^{↓29.1}	5 555 ^{↑34.0}	5 051 ^{↓9.1}	4 757 ^{↓5.8}	4 619 ^{↓2.9}	
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	135 663 ^{↑49.7**}	3 042 ^{↓97.8}	2 678 ^{↓12.0}	2 849 ^{↑6.4}	3 019 ^{↑1.1}	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	5 314 ^{↑2.3**}	4 978 ^{↓6.3}	5 044 ^{↑1.3}	7 110 ^{↑41.0}	7 167 ^{↑0.8}	
Хэрэглээний үнийн индекс, (жилийн өөрчлөлт)	Хувь	1.0 ^{↓1.0}	1.4 ^{↑0.4}	0.6 ^{↓0.8}	1.8 ^{↑1.2}	0.4 ^{↓1.4}	
Доллар (АНУ)	Төгрөг	2 857 ^{↑0.2}	3 508 ^{↑22.8}	3 392 ^{↓3.3}	3 459 ^{↑2.0}	3 561 ^{↑3.8}	
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Юань (БНХАУ)	Төгрөг	451 ^{↑2.3}	514 ^{↑14.0}	472 ^{↓8.2}	475 ^{↑0.6}	511 ^{↑8.7}
	Рубль (ОХУ)	Төгрөг	36 ^{↓5.3}	48 ^{↑33.3}	37 ^{↓22.9}	38 ^{↑2.7}	46 ^{↑35.3}
Нийслэлийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	153.2 ^{↑22.2}	236.5 ^{↑54.4}	424.4 ^{↑79.5}	518.1 ^{↑22.1}	529.0 ^{↑2.1}	
Нийслэлийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	93.1 ^{↓34.7}	173.5 ^{↑86.4}	283.7 ^{↑63.5}	770.5 ^{↑27**}	709.3 ^{↓7.9}	
Агаарын дундаж температур	°C	-17.0	-21.0	-18.8	-16.4	-15.2	


ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 II						2026 II					
		Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага			Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	Баянгол	8 797	Налайх	59	380	Баянгол	9 488	Налайх	62		
			Чингэлтэй	1 490	Багануур	47		Чингэлтэй	1 569	Багахангай	49		
			Сүхбаатар	688	Багахангай	32		Сүхбаатар	730	Багануур	31		
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	15	Чингэлтэй	19	Налайх	-	14	Багануур	31	Чингэлтэй	7		
			Сонгинохайрхан	14	Багануур	-		Сүхбаатар	22	Баянгол	6		
			Сүхбаатар	13	Багахангай	-		Сонгинохайрхан	13	Багахангай	0		
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	18	Баянзүрх	19	Хан-Уул	11	18	Багануур	20	Сүхбаатар	10		
			Сүхбаатар	15	Налайх	5		Баянзүрх	17	налайх	7		
			Сонгинохайрхан	14	Багахангай	5		Чингэлтэй	12	Багахангай	0		
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	67	Баянзүрх	224	Налайх	119	75	Хан-Уул	178	Багануур	79		
			Хан-Уул	186	Багахангай	83		Баянзүрх	169	Налайх	41		
			Сүхбаатар	144	Багануур	31		Сүхбаатар	129	Багахангай	23		
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	64	Сүхбаатар	105	Сонгинохайрхан	49	60	Сүхбаатар	96	Багануур	37		
			Чингэлтэй	81	Налайх	21		Чингэлтэй	85	Налайх	23		
			Баянгол	67	Багахангай	13		Хан-Уул	65	Багахангай	17		



ЭРҮҮЛ МЭНД 2026 оны эхний II сард

Үндэсний
сүлжээ

Амаржсан эх 	2025 II	838	
	2026 II	819	2.3% ↓
Шинээр төрсөн хүүхэд	2025 II	844	
	2026 II	833	1.3% ↓



Нийт халдварт өвчнөөр өвчлөгсөд

 	2025 II	484	
	2026 II	386	20.2% ↓



0-1 насны хүүхдийн эндэгдэл	2025 II	12
	2026 II	11
1-5 насны хүүхдийн эндэгдэл	2025 II	3
	2026 II	1



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний II сард 386 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 98 (20.2%) хүнээр буурсан байна.


Дүүргийн хэмжээнд 2026 оны II сарын байдлаар 386 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 98 (20.2%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 2.9 (20.4%) хүнээр буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 27 (7%) цусан суулга, 12 (3.1%) улаан эсэргэнэ, 3 (0.8%) гепатит, 58 (15%) салхин цэцэг, 1 (0.3%) гахайн хавдар, 6 (1.6%) сальмонеллэз, 1 (0.3%) ёлом, 11 (2.8%) гар хөл, амны өвчин, 65 (16.8%) улаанбурхан, 13 (3.4%) эритема B08.3, 52 (13.5%) тэмбүү, 28 (7.3%) заг хүйтэн, 42 (10.8%) шинээр илэрсэн сүрьеэ, 30

(7.8%) трихомониаз, 8 (2%) B34.1 энтеровируст халдвар, 29 (7.5%) бусад халдварт өвчлөгчид тус тус эзэлж байна. Халдварт өвчнийг өмнөх онтой харьцуулахад гепатит 1 (25%), салхинцэцэг 106 (64.6%), сальмонеллэз 1 (14.3%), ёлом 5 (83.3%), тэмбүү 58 (52.3%), заг хүйтэн 22 (44%), трихомониаз 27 (47.4%) тус тус буурсан байна. Харин цусан суулга 4 (17.4%), улаан эсэргэнэ 5 (71.4%), ГХА өвчин 5 (83.3%), эритема B08.3 6 (85.7%), шинэ илэрсэн сүрьеэ 2 (5%), тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 3. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	2024 I-II	2025 I-II	2026 I-II	Өсөлт, бууралт	
					2026/2025	тоо/нэгж
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо	416	484	386	-98	-20.2
Үүнээс цочмог халдварт өвчин	Бодит тоо	223	226	205	-21	-9.3
Цусан суулга	Бодит тоо	43	23	27	4	17.4
Улаан эсэргэнэ	Бодит тоо	17	7	12	5	71.4
Менингит	Бодит тоо	-	-	-	-	-
Гепатит	Бодит тоо	5	4	3	-1	-25.0
Салхинцэцэг	Бодит тоо	125	164	58	-106	-64.6
Гахайн хавдар	Бодит тоо	6	-	1	1	-
Сальмонеллэз	Бодит тоо	4	7	6	-1	-14.3
Ёлом	Бодит тоо	5	6	1	-5	-83.3
ГХА өвчин	Бодит тоо	14	6	11	5	83.3
Улаан бурхан	Бодит тоо	-	-	65	65	-
Хоолны хордлого	Бодит тоо	4	-	-	-	-
Эритема B08.3	Бодит тоо	0	7	13	6	85.7
Тэмбүү	Бодит тоо	67	111	53	-58	-52.3
Заг хүйтэн	Бодит тоо	30	50	28	-22	-44.0
Шинэ илэрсэн сүрьеэ	Бодит тоо	48	40	42	2	5.0
Трихомониаз	Бодит тоо	24	57	30	-27	-47.4
B34.1 Энтеровируст халдвар	Бодит тоо	48	-	8	8	-

ЗУРАГ 1. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, ТӨРЛӨӨР



2026 оны II сарын байдлаар 819 эхээс 833 хүүхэд мэндэлсэн байна. Өнгөрсөн оны мөн үед 899 эхээс 902 хүүхэд мэндэлж байжээ. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 11 гарсан

нь өмнөх оны мөн үеээс 1 (8.3%) буурсан байна. 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1 гарсан нь өмнөх оны мөн үеээс 2 (66.7%) буурсан байна.

ХҮСНЭГТ 4. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ II САРД

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Эхний улирал			Зөрүү	
		2024 I-II	2025 I-II	2026 I-II	Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	тоо	899	838	819	-19	-2.3
Амьд төрсөн хүүхэд	тоо	902	844	833	-11	-1.3
Нийт нас баралт	тоо	329	259	246	-13	-5.0
0-1 насны хүүхдийн эндэгдэл	тоо	15	12	11	-1	-8.3
1-5 насны хүүхдийн эндэгдэл	тоо	2	3	1	-2	-66.7
Төрөхийн улмаас эндсэн эх	тоо	1	-	-	-	-

Эмнэлгийн байгууллагууд 2026 оны II сарын байдлаар 195150 хүн үзлэг хийсний 76039 (39%) нь урьдчилан сэргийлэх, 47932 (24.6%) нь гэрийн үзлэг байна. Тайлант хугацаанд 133 эх шинээр жирэмсний хяналтад орсноос 3 (2.3%) нь цус багадалттай, 4 (3%) трихомониаз, 1 (0.8%) заг хүйтэн, 4 (3%) тэмбүү тус тус өвчлөл эерэг гарсан байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 129 (97%) нь жирэмсний эхний 3 сартайдаа хяналтад

орсон байна. 2026 оны II сарын байдлаар артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 22586 хүн хамрагдсанаас 13359 (59.1%) эмэгтэйчүүд байна. Үүнээс давтан үзлэгт 558 (2.5%) нь хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт 14894 хүн хамрагдсанаас 8778 (58.9%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан нийт хүний 10412 (55.6%) нь артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн

үзлэгт, 6825 (36.4%) нь чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт, 1506 (8%) нь элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт тус тус хамрагдсан байна.

Тайлант хугацаанд 0-5 насны 10913 хүүхдийн өсөлтийн үндсэн үзүүлэлтийг шалгахад 0-5

насны хүүхдүүдийн 19 (0.2%) нь туранхай, 12 (0.1%) нь тураалтай, 12 (0.1%) нь өсөлтийн хоцрогдолтой хүүхэд байсан байна. Амбулатороор үйлчлүүлсэн 0-5 насны 102 хүүхэд А амин дэм, 5640 хүүхэд Д амин дэм тус тус уусан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт:

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):

Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.


Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв




ДҮҮРГИЙН ТӨСӨВ 2026 оны II сар, тэрбум төгрөг

Авгуур




Төсвийн орлогын бүтэц



- Татварын орлого
- Татварын бус орлого

Татварын орлогын бүтэц



- Орлогын албан татвар
- Өмчийн татвар
- Бусад татвар



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 7.1

хувиар өслөө.

Дүүргийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2026 оны II дугаар сард 22306.2 (70.0%) сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 9581.9 (30.0%) сая төгрөгөөр дутуу бүрдсэн бол өмнөх оны мөн үеэс 1708.4 (7.1%) сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн нийт орлогын гүйцэтгэлийн 21852.3 (98.0%) сая төгрөгийг татварын орлого, 353.9 (2.0%) сая төгрөгийг татварын бус орлого бүрдүүлжээ. Нийт татварын орлогод 18085.9

(82.8%) сая төгрөгийг орлогын албан татвар, 1053.6 (4.8%) сая төгрөгийг өмчийн татвар, 1965.1 (9.0%) сая төгрөгийг газрын төлбөр, 847.7 (3.4%) сая төгрөгийг бусад төлбөр хураамж тус тус эзэлж байна. Тайлант хугацааны өмчийн татварын гүйцэтгэл төлөвлөсөн төсвөөс 122.6 (13.2%) сая төгрөгөөр давж биелсэний 99.2%-ийг үл хөдлөх хөрөнгийн албан татвар бүрдүүлжээ.


ХҮСНЭГТ 5. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 ОНЫ ЭХНИЙ II САРД

Үзүүлэлт	Төсвийн орлого /сая.төг/		Өөрчлөлт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31 888.1	22 306.2	-9 581.9	-30.0
1. Татварын орлого	31 502.6	21 952.3	-9 550.3	-30.3
1.1 Хувь хүний орлогын албан татвар	27 201.4	18 085.9	-9 115.5	-33.5
1.1.1.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	14 999.6	11 169.1	-3 830.5	-25.5
1.1.2. Үйл ажиллагааны орлого	1 889.5	1 602.3	-287.2	-15.2
1.1.3. Хөрөнгийн орлого	2 876.6	2 668.5	-208.1	-7.2
1.1.4. Хөрөнгө борлуулсны орлого	1 827.7	1 033.4	-794.3	-43.5
1.1.5. Шууд бус орлого	5 608.0	1 612.6	-3 995.4	-71.2
1.2. Хөрөнгийн албан татвар	931.0	1 053.6	122.6	13.2
1.2.1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	924.4	1 045.0	120.6	13.0
1.2.2. Бууны албан татвар	5.6	7.5	1.9	33.9
1.2.3. Малд ногдуулах албан татвар	1.0	1.1	0.1	10.0
1.3. Бусад татвар, төлбөр хураамж	1 761.5	1 046.8	-714.7	-40.6
1.3.1 Бусад нийтлэг төлбөр хураамж	685.8	163.0	-522.8	-76.2
1.3.1.1. Улсын тэмдэгтийн хураамж	45.8	83.5	37.7	82.3
1.3.1.2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	7.0	0.3	-6.7	-95.7
1.3.1.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1 234.4	762.9	-471.5	-38.2
1.3.2. Газрын төлбөр	1 071.7	883.4	-188.3	-17.6
1.3.3. Байгалийн нөөц ашигласны төлбөр	4.8	1.0	-3.8	-79.2
1.3.3.1 Ус рашаан ашигласны төлбөр	4.8	1.0	-3.8	-79.2
2.Татварын бус орлого	385.5	353.9	-31.6	-8.2
2.1.Нийтлэг татварын бус орлого	-	-	-	-
2.1.1. Торгуулийн орлого	215.5	231.9	16.4	7.6
2.1.2. Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	20.0	18.4	-1.6	-8.0
2.1.3 Бусад орлого	150.0	103.6	-46.4	-30.9

ХҮСНЭГТ 6. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, 2026 ОНЫ ЭХНИЙ II САРД

Дүн	Төсвийн орлого			Үүнээс:					
	Бүгд	Биелэлт %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого		
				Бүгд	Биелэлт %	Зөрүү сая.т	Бүгд	Биелэлт %	Зөрүү сая.т
Дүн	22 306.2	70.0	-9 581.9	21 952.3	69.7	-9 581.9	353.9	91.8	-31.6

ЗУРАГ 2. ТӨСВИЙН ОРЛОГО, САРААР



Оны эхний II дугаар сард төсвийн нийт орлогын төлөвлөгөө 16617.1 сая төгрөг, гүйцэтгэл 13 717.4 сая төгрөгт хүрч 82.5 хувьтай

биелжээ. Энэ нь өнгөрсөн оны II сараас төсвийн орлогын төлөвлөгөө 11.3 хувиар өсч, гүйцэтгэл 13.4 хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 7. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 ОНЫ ЭХНИЙ II САРД

Үзүүлэлт	Батлагдсан төсөв жилээр	Төсвийн зарлага/сая.төг/		Өөрчлөлт	
		Төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Хувь
НИЙТ ЗАРЛАГА	223 048.1	29 990.2	22 823.1	-7 167.1	-23.9
Урсгал зардал	174 097.2	24 426.6	19 276.6	-5 150.0	-21.1
Бараа, ажил үйлчилгээний зардал	160 406.4	22 264.9	17 087.2	5 177.7	-23.3
Урсгал шилжүүлэг	13 690.8	2 161.7	2 189.4	-27.7	-1.3
Хөрөнгийн зардал	48 950.9	5 563.6	3 546.3	-2 017.1	-36.3

Дүүргийн оны эхний II сарын батлагдсан төсвийн зарлага 29 990.2 сая төгрөг бөгөөд 2026 оны нийт батлагдсан төсвийн 13.4%-ийг эзэлж байна. Үүнээс 76.1 хувь буюу 22 823.1 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ сарын зарцуулсан

зардлын 84.5 хувийг урсгал шилжүүлгийн зардал, 15.5 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

ЗУРАГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГА, ОНЫ ЭХНИЙ II САРААР



2026 оны эхний II сарын төсвийн төлөвлөсөн зардал өмнөх оны мөнх үеэс 12867.4 (30.0%) сая төгрөгөөр буурсан бол гүйцэтгэл 3255.6 (16.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого:

Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал:

Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Урсгал зардал:

Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Татварын бус орлого:

Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого:

Тогтворжуулалтын сан, ирээдүйн өв сан, хуримтлалын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв:

Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг Даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс.



НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл оны эхний II сард 19.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт орлогын төлөвлөгөө 2026 оны II сард 36.7 тэрбум, гүйцэтгэл 36.6 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 99.7 хувьтай биелсэн байна. Үүний 83.3%-ийг


тэтгэврийн даатгал, 8.9%-ийг тэтгэмжийн даатгал, 4.8%-ийг ҮОМШӨ-ний даатгал, 3.0%-ийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 8. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, 2026 ОНЫ II САРД

Үзүүлэлт	2026 I-II	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	сая төгрөг	
Нийт орлого	36 679.4	36 575.0
Тэтгэврийн даатгалын сан	30 300.4	30 478.0
Тэтгэмжийн даатгалын сан	3 250.3	3 240.2
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сан	2 018.9	1 753.5
Ажилгүйдлийн даатгалын сан	1 109.9	1 103.3

ҮОМШӨ¹-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ХУВИАР



Нийгмийн даатгалын сангаас 2026 оны эхний II сард 102801.0 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг 99434 хүнд олгожээ. Үүний 87758.5 (85.4%) сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 5540.4 (5.4%) сая төгрөгийг тэтгэмжийн

даатгалын сангаас, 584.1 (0.6%) сая төгрөгийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас, 8917.9 (8.6%) сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас тус тус олгосон байна. Тэтгэврийн даатгалын сангийн 79.0%-ийг өндөр насны тэтгэвэр, 9.1%-


ийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэвэр, 3.1%-ийг Тэжээгчээ алдсаны тэтгэвэр,

8.8%-ийг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр болон бусад зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 9. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ

Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо	2026 I-II	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
		сая төгрөг	
Нийт олгосон тэтгэвэр, тэтгэмж	99 434	103 478.0	102 801.0
1 Тэтгэврийн даатгалын сан	93 117	86 774.1	87 758.5
1.1.Өндөр насны тэтгэвэр	73 064	69 059.6	69 291.4
1.2.Хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр	11 292	7 688.5	7 984.1
1.3.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	3 744	2 413.8	2 695.6
1.4.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	5 017	7 602.4	7 781.2
1.5.Бусад зардал	-	9.7	6.2
2 Тэтгэмжийн даатгалын сан	2 856	6 962.1	5 540.4
2.1.ХЧТА тэтгэмж	1 337	668.2	567.8
2.2.Жирэмсний болон амаржсаны	1 150	5 300.3	4 221.4
2.3.Нас барсан даатгуулагчийн гэр бүлд олгох тэтгэмж	369	888.0	716
2.4.Бусад зардал	-	105.6	35.2
3 ҮОМШӨ-ний даатгалын сан	530	633.5	584.1
3.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	435	513.3	471.6
3.2.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	74	74.0	88.0
3.3.ҮОМШӨ тэтгэмж	21	31.3	24.5
3.4.ҮОМШӨ сувиллын зардал	-	14.6	-
3.5.Бусад зардал	-	0.3	-
4 Ажилгүйдлийн даатгалын сан	2 931	9 108.3	8 917.9
4.1.Ажилгүйдлийн тэтгэмж	2 931	9 108.3	8 917.9
4.2.Бусад зардал	-	-	-

ЗУРАГ 5. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, II САРД



Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал:

Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Тэтгэмж:

Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наадзахын

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын газар

хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Нийгмийн даатгалын сан:

Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тэтгэвэр:

Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Даатгуулагч:

Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Сонгинохайрхан дүүрэгт нийгмийн халамжийн зарлага 2026 оны II сард 46.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэршээлтэй иргэн зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн арга хэрэгсэл юм. Сонгинохайрхан дүүргийн нийгмийн

халамжийн сангаас 2026 оны эхний II сард 203.5 мянган хүнд 46903.0 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдсон байна.

ХҮСНЭГТ 10. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, оны эхний II сард

Үзүүлэлт	2026 I-II		Нийт халамжийн санд эзлэх хувь
	Хүн	Гүйцэтгэл	
	Тоо	Сая төгрөг	
Нийт	203 503	46 903.0	100
Нийгмийн халамжийн тэтгэвэр	6 519	6 047.7	12.9
Асаргааны тэтгэмж	6 584	4 578.0	9.8
Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	13 419	1 258.8	2.7
Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж	3	0.9	0.002
Хүүхдийн мөнгө	132 090	26 349.5	56.2
Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж	17	20.4	0.04
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	1 947	1 259.2	2.7
Ахмад настны хөнгөлөлт, тусламж	739	174.2	0.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	472	109.6	0.2
Алдарт эхийн одон	23 478	5 623.8	12.0
Насны хишиг	18 235	1 480.9	3.1

Олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн 26349.5 (56.2%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 6047.7 (12.9%) сая төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэр, 5623.8 (12.0%) сая төгрөгийг алдарт эхийн одонгийн тэтгэмж, 4578.0 (9.8%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 1480.9 (3.058%) сая төгрөгийг насны хишгийн тэтгэмж, 1259.2 (2.7%) сая төгрөгийг

амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 1258.8 (2.7%) сая төгрөгийг эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж, үлдсэн 305.1 (0.642%) сая төгрөгийг алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж, ахмад настны хөнгөлөлт, тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 11. АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, төрлөөр, оны эхний II сард

Үзүүлэлт	2026 I-II		Нийт ахмад настны тэтгэмж, хөнгөлөлтөнд эзлэх хувь
	Хүн	Гүйцэтгэл	
	Тоо	Сая төгрөг	
Нийт	739	174.2	100
Оршуулгын тэтгэмж	8	19.0	10.9
Рашаан сувилал	160	56.1	32.2
Протез	495	65.7	37.7
Ортопед, тусгай хэрэгсэл	76	33.4	19.2

Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлтийн 56.1 (32.2%) сая төгрөгийг рашаан сувилалд амрах хөнгөлөлт, 65.7 (37.7%) сая төгрөгийг протез /Сүүж-түнхний үе, өвдөгний үе, сүүж-түнх, дунд чөмөг, шилбэ, шилбэний түгжээт хадаас, өвдөгний тулгууртай шилбэний, тавхай, тавхайн урд хэсэг, мөр, бугалга, тохой, шуу, сарвуу, хуруу,

хиймэл шүд, эрүү, зүрхний хиймэл хавхлага, гавлын титан бүрхэвч, дунд чихний титан, шилэн нүд, хуванцар нүд, нүдний болор, нүдний уян болор зэргийг суулгах/-ийн хөнгөлөлт, 19 (10.9%) сая төгрөгийг оршуулгын тэтгэмж, 33.4 (19.2%) сая төгрөгийг ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 12.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛТ, тусламж, төрлөөр, оны эхний II сард

Үзүүлэлт	2026 I-II		Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжинд эзлэх хувь
	Хүн	Гүйцэтгэл	
	Тоо	Сая төгрөг	
Нийт	472	109.6	100
Оршуулгын тэтгэмж	15	40	36.5
Харилцаа, холбооны зардал	235	9.3	8.5
Рашаан сувилал	11	3.9	3.6
Цэцэрлэг, сургуулийн унааны хөнгөлөлт	45	9.0	8.2
Ортопед, тусгай хэрэгсэл	57	31.7	28.9
Протез	32	4.9	4.5
Түлш, орон сууцны үнийн хөнгөлөлт	77	10.8	9.8

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийн 40 (36.5%) сая төгрөгийг оршуулгын тусламж, 31.7 (28.9%) сая төгрөгийг ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, 10.8 (9.8%) сая төгрөгийг түлш, орн сууцны хөнгөлөлт, 9.0(8.2%) сая төгрөгийг цэцэрлэг, сургуулийн унааны хөнгөлөлт, 9.3 (8.5%) сая төгрөгийг харилцаа, холбооны зардал, 3.9 (3.6%) сая төгрөгийг рашаан сувиллын хөнгөлөлт, 4.9 (4.5%)

сая төгрөгийг протез /Сүүж-түнхний үе, өвдөгний үе, сүүж-түнх, дунд чөмөг, шилбэ, шилбэний түгжээт хадаас, өвдөгний тулгууртай шилбэний, тавхай, тавхайн урд хэсэг, мөр, бугалга, тохой, шуу, сарвуу, хуруу, хиймэл шүд, эрүү, зүрхний хиймэл хавхлага, гавлын титан бүрхэвч, дунд чихний титан, шилэн нүд, хуванцар нүд, нүдний болор, нүдний уян болор зэргийг суулгах/-ийн хөнгөлөлт тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн халамж:

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Байнгын асаргаа шаардлагатай иргэн:

Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

Бүтэн өнчин хүүхэд:

Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

Өрх толгойлсон эх /эцэг/:

Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ

шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ:

Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй

иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.

Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн халамжийн хэлтэс



ГЭМТ ХЭРЭГ

2026 оны эхний II сард

ᠮᠤᠩᠭᠡᠷ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2025 II

1097


2026 II

956

4.8%



Дүүргээр



Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

892



Гэмтсэн хүн

164



Нас барсан хүн

39



ГЭМТ ХЭРЭГ

Сонгинохайрхан дүүрэгт 2026 оны II сард 956 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 141 (12.8%) хэргээр буурсан байна.

Монгол улсад 2026 оны эхний II сард нийт 10267 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд 7167 (69.8%) орон нутагт 3100 (30.2%), дүүрэгт 956 (9.3%) гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн

үетэй харьцуулахад улсын хэмжээнд 73 (0.7%), нийслэлийн хэмжээнд 57 (0.8%) хэргээр тус тус өссөн бол, дүүргийн хэмжээнд 141 (12.9%) хэргээр буурсан байна.

ХҮСНЭГТ 13. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хэлтсээр, оны эхний II сард

Хэлтэс	2025 I-II	2026 I-II	Өөрчлөлт		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
	Тоо	Тоо	Тоо	Хувь	
Нийт гэмт хэрэг	1097	956	-141	-12.8	100.0
СХДЦХ-1	510	377	-133	-26.1	39.4
СХДЦХ-2	301	304	3	1.0	31.8
СХДЦХ-3	286	275	-11	-3.8	28.8

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Цагдаагийн 1 дүгээр хэлтэст 133 (26.1%), Цагдаагийн 3 дугаар хэлтэст

11 (3.8%) хэргээр тус тус буурсан бол Цагдаагийн 2 дугаар хэлтэст 3 (1.0%) хэргээр өссөн байна.


ХҮСНЭГТ 14. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, оны эхний II сард

Төрөл	2025 I-II	2026 I-II	Өөрчлөлт		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
	Тоо	Тоо	Тоо	Хувь	
Нийт гэмт хэрэг	1 097	956	-141	-12.8	100.0
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	33	37	4	12.1	3.9
Хүнийг алах гэмт хэрэг	4	1	-3	-75	0.1
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	217	140	-77	-35.5	14.6
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхгэмт хэрэг	4	3	-1	-25	0.3
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	21	8	61.5	2.2
Хүчиндэх гэмт хэрэг	1	3	2	3**	0.3
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	8	1	-7	-87.5	0.1
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	1	-1	-50	0.1
Хулгайлах гэмт хэрэг	275	170	-105	-38.2	17.8
Дээрэмдэх гэмт хэрэг	52	32	-20	-38.5	3.3
Залилах гэмт хэрэг	303	359	56	18.2	37.5
Хөрөнгө завших гэмт хэрэг	16	17	1	6.2	1.8
Алдаатай гүйлгээ андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг	44	32	-12	-27.3	3.3
Автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	4	5	1	25	0.5
Эд хөрөнгө устгах, гэмтээх	19	23	4	21	2.4
Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	7	27	20	3.9**	2.8
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	11	19	8	72.7	2.0
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	2	-2	-50	0.2
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	7	5	-2	-28.6	0.6
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11	12	1	9.1	1.3
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	62	46	-16	-25.8	4.9

